

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар,
Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Компанийн дэд бүтцийн байгууламжийг өргөтгөх, сайжруулах, шинээр суурилуулах зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг урт, дунд болон богино хугацаагаар төлөвлөх, ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх

Албан тушаалын зорилт:

- Дэд бүтэц /барилга, цамхаг, кабель шугам/ шинээр барих, засварлах зэрэг хөрөнгө оруулалтыг оновчтой зохион байгуулах, аймаг ашиглалтын газруудын саналыг нэгтгэн, худалдан авах ажиллагааны хэлтэстэй хамтарч ажиллах
- Дэд бүтцийн байгууламжийг өргөтгөх, сайжруулах, шинээр суурилуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулах, хянах
- Байгууллага, иргэний хүсэлтээр дэд бүтэц түрээсээр ашиглуулах техникийн нөхцөл боловсруулах, олгох, түүний дагуу гэрээ хийлгүүлэх
- Цамхагийн ашиглалтын судалгааг жил бүр хийх, эрсдэлийг бууруулах
- Удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, бусад газар нэгжтэй хамтарч ажиллах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх

Зорилт

Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг

1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none">Аймгийн болон ашиглалтын газруудаас цамхагт хийгдэх хөрөнгө оруулалтын санал авах, нэгтгэж батлуулах, хөрөнгө оруулалтыг оновчтой зохион байгуулах, төлөвлөхТөлөвлөсөн ажлын үр ашиг тооцооллыг гаргах, шаардлагатай тохиолдолд газар дээр нь албан томилолтоор явж ажиллах,Тендерийн үнэлгээний хороонд ажиллаж, ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахад санал өгөхШаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулалтын ажлын Захиалагчийн төлөөлөгчөөр ажиллах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэл болон баталгаат хугацаанд хяналт тавих, гэрээнд өөрчлөлт оруулах, стандартыг хангуулах шаардлагатай тохиолдолд гарсан зөрчлийг арилгуулах шаардлага хүргүүлэх
---------------------------	--

2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Улсын төсөвийн болон бусад эх үүсвэрээр хийгдсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах, ашиглалтын төлөвлөлтийг хийхэд санал оруулах 2. Хөрөнгө оруулалтаар хийгдэх цамхагийн ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгаварыг хянах, шинээр боловсруулж, батлуулах 3. Ажлын даалгавар дээр шаардлагатай тохиолдолд мэргэшсэн төсөвчинтэй хамтарч ажиллах, мөн ашиглагч салбар, нэгжийн саналыг тусгах, 4. Ажлын даалгаварт холбогдох хууль эрх зүйн актууд, стандарт, норм ба дүрэм, журмыг уншиж судлах, ашиглах,
3 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага, иргэний хүсэлтээр барилга байгууламж, цамхагт антенн тоног төхөөрөмж байрлуулах болон байр талбай түрээсээр ашиглуулах техникийн нөхцөл боловсруулах, олгох, 2. Олгосон техникийн нөхцөлийн хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ хийлгүүлэх талаар Борлуулалтын хэлтэстэй хамтарч ажиллах
4 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Цамхагийн ашиглалтын судалгааг жил бүр хийх, 2. Эрсдэлтэй цамхагийг шийдвэрлэх, буулгах шинэчлэхэд санал оруулах 3. Ашиглалтгүй цамхагийг шилжүүлэх тооцоо судалгааг хийж санал оруулах
5 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Удирдлагыг мэдээллээр хангах, ажлаа тайлагнах, танилцуулах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх 2. Шаардлагатай тохиолдолд хөрвөж ажиллах

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр
Мэргэжил	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/;
Мэргэшил	Мэргэшил шаардахгүй. Мэргэшсэн бол давуу тал болно.
Туршлага	Мэргэжлээрээ 15-аас дээш, Харилцаа холбооны салбарт 15-аас дээш жил ажилласан
Ур чадвар	Удирдан зохион байгуулах, багаар ажиллах, асуудалд дүн шинжилгээ хийх, бүтээлч санаачилгатай, баримт, бичиг боловсруулах, гадаад хэлний зохих мэдлэгтэй, хэрэглээний программ дээр ажиллах чадвартай байх.
Ажлын байрны болон орон нутгийн онцлог, цаг үеийн нөхцөл байдал, хүний нөөцийн хэрэгцээг үндэслэн энэхүү тусгай шаардлагын "Туршлага" хэсэгт заасныг тухайн тохиолдолд өөрчлөн тогтоож болно.	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Газрын захирал, хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Хэлтсийн мэргэжилтнүүд Нийт: 10	Бусад харилцах субъект: 1. Компанийн нийт ажилтнууд 2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

БОЛОВСРУУЛСАН:	БАТАЛСАН:
<p>ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p>.....</p> <p>А.ГАНТУЛГА</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>	<p>ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p>УЛААНБААТАР ХОТ</p> <p>МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ С.Д.МЯНГАНБААТАР ХХК</p> <p>9022050763 5081092 СБТ18969</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>